

2023 оны 10 дугаар сарын 09 -ны өдөр

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн батласан хавсралт 1 “Монгол улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх олон улсын тээврийн хэрэгслээс авах төлбөрийн хэмжээ” хавсралт 2 “Олон улс улсын чанартай авто зам замын байгууламж ашиглан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн задрах боломжгүй ачаа тээвэрлэх тээврийн хэрэгслээс авах төлбөрийн хэмжээ” Дугаар 222 тогтоолын дагуу Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны 08 дугаар 22 -ны өдрийн А/226 дугаар тушаалаар “Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламж ашигласны төлбөр авах журам” батлагдсан.

Дээрх тогтоол, журмын дагуу 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн төлбөрүүдийг авто замын санд төвлөрүүлэн ажиллах болсон тул аж ахуйн нэгж, байгууллага иргэдээс зөвшөөрөл хүсэхэд шаардагдах материалыг доорх жагсаалтаар хүргүүлж байна.

1. Албан хүсэлт
 - Тээвэрлэх ачаа задрах боломжгүй ачааны төрөл холбогдох мэдээлэл / урт, өргөн, өндөр нийт жин тонн /
 - Тээвэрлэх тээврийн хэрэгсэл, чиргүүлийн улсын дугаар, чиргүүлийн төрөл / дугаар аваагүй тээврийн хэрэгслийн хувьд арлын дугаар тусгах/
 - Жолоочийн мэдээлэл /Овог нэр жолооны үнэмлэх дугаар/
 - Тээвэрлэлт хийх маршрут чиглэл /Хатуу хучилттай болон ердийн хөрсөн замаар зорчих нийт км-н урт/
 - Тээвэрлэлт хийх хугацааг нарийн тодорхойлон тусгах
 - Холбогдох хариуцсан хүний утасны дугаар зэргийг тусгах ирүүлнэ.
2. Тээврийн хэрэгсэл, чиргүүлийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
3. Ачааны мэдээлэл /Packing list, Гаалийн мэдүүлэг, Автопүүгээр пүүлүүлсэн хуудас/
4. Жолооны үнэмлэхний хуулбар
5. Авто зам ашигласны төлбөр төлсөн баримт / www.ezam.mn дээр үүссэн нэхэмжлэл төлсөн эсэх /
6. Тээврийн хэрэгсэл, чиргүүл, ачааг ачсан үеийн 4 талаас авсан фото зураг хавсаргах /Тээврийн хэрэгсэл, чиргүүл, арлын дугаар зэргийг тод оруулсан байх/

Эдгээр баримтыг үндэслэн Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын “Задрах боломжгүй, овор ихтэй ачаа тээвэрлэх” зөвшөөрлийг олгосоноор “Задрах боломжгүй овор ихтэй ачааг даац хэтрүүлэн тээвэрлэхэд зориулсан төлбөрийг тарифын дагуу Төрийн сангийн 100900028054 тоот дансанд тушаана. /гүйлгээний утга: Тээврийн хэрэгсэл, чиргүүлийн улсын дугаар, арлын дугаар заавал бичих/

Зөвшөөрөл аваагүй, төлбөр төлөөгүй тээврийн хэрэгслийг төлбөр авах цэгт саатуулан Засгийн газраас тогтоосон хэмжээгээр төлбөр, торгуулийг төлүүлэх арга хэмжээ авч ажиллана.

Хавсралтаар: 222 тогтоолын 2-р хавсралт, журам А226

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759590875551&showType=1&fbclid=IwAR1eMv6qmmn3Ue0OKclGBbILBKo0jT9uW2jcRGmDniG7PdRuTpiBBmlGKXo>